



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 5/12

Бор-өндөр сум

**Н.Насанбатыг тасгийн
эрхлэгчээр томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Монгол Улсын Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны MNS5095:2017 стандартыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мэс заслын эмч Н.Насанбатыг 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэвтэн эмчлүүлэх 2-р тасгийн эрхлэгчээр томилсугай.
2. Н.Насанбатын тасгийн эрхлэгчийн хариуцлагын нэмэгдлийг үндсэн цалингийн 10%-иар тооцож олгохыг Нягтлан бодогч (Т.Эрдэнэболор)-т зөвшөөрсүгэй.
3. Хэвтэн эмчлүүлэх 2-р тасгийн зохион байгуулалт, үйл ажиллагааг удирдлагаар хангаж, чиг үүрэг өгч ажиллахыг тасгийн эрхлэгч (Н.Насанбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА

А.БАТБААТАР

